

Өнгөний тайлбар:

~~Хассан~~

Нэмсэн, өөрчилсөн

## “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн нэр томьёо

1.3.1. ~~"Агаарын тээвэрлэгчийн шуудан ба эд зүйлс" гэж агаарын тээвэрлэгчийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан өөрийн эсхүл гэрээт байгууллагад хүргүүлэх зорилгоор тээвэрлэгдэх бичиг баримт, хангамжийн материал, техник үйлчилгээний сэлбэг, нислэгийн хөөл хүнс, цэвэрлэгээний болон бусад зүйлсийг;~~

ИНД-ийн нэр томьёоны тайлбар:

**Шуудангийн эд зүйл / Postal article** гэж захидал, илгээмж, эсхүл дараах эд зүйлийг багтаасан, шуудангаар илгээсэн болон хүргэгдээгүй бусад эд зүйлийг (ИНД-92):

(1) хүргэсэн боловч, хүлээн авагчийн гарт очоогүй эд зүйл;

(2) захидал, илгээмж, эсхүл эд зүйлийн агууламж;

1.3.2. "Албадан гаргаж байгаа гадаадын иргэн" гэж Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-д заасны дагуу Монгол Улсаас албадан гаргагдаж буй этгээдийг;

1.3.3. "Барааг чөлөөлөх" гэж гаалийн бүрдүүлэлт хийгдсэний дараа гаалийн байгууллагаас **ын зүгээс** хүлээн авагчид барааг чөлөөт эргэлтэд оруулах зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Барааг чөлөөлөх / Release of goods** гэж Гаалийн бүрдүүлэлт хийсний дараа гаалийн байгууллагаас хүлээн авагчид барааг чөлөөт эргэлтэд оруулах зөвшөөрөл олгох үйл ажиллагааг (AN 9)

1.3.4. "Буулгах үйл ажиллагаа" гэж агаарын хөлөг газардсаны дараа зорчигч, ачаа, тээш, шуудан, илгээмжийг агаарын хөлгийн тавцангаас буулгах ажиллагааг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Буулгах / Unloading** гэж буулт үйлдсэний дараа агаарын хөлгөөс ачаа, шуудан, тээш, эсхүл бүхээгийн нөөцийг буулгах (AN 9)

1.3.5. ~~"Гадаад улсад зөрчих Аяллын баримт бичиг" гэж Монгол Улсын иргэний хувьд үндэсний гадаад паспорт, Монгол Улс руу буцах үнэмлэх, гадаадын иргэний хувьд тухайн улсаас гадаад улсад зөрчих хүчин төгөлдөр паспорт, эсхүл буюу паспортыг орлох баримт бичгийг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Аяллын баримт бичиг / Travel document** гэж эрх бүхий эзэмшигч нь олон улсын аялалд ашигладаг, тухайн улс, эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон паспорт, эсхүл бусад албан баримт бичгийг (AN 9)

1.3.6. "Гаалийн түр зөвшөөрөл" гэж ~~гаалийн нутаг дэвсгэрт оруулж байгаа тодорхой нэр төрлийн барааг тусгай нөхцөл болзолтойгоор импортын татвар, хураамжаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ажиллагааг (эдгээр бараа нь тусгайлсан зорилго, хэрэглээний дагуу импортлогдох эсвэл тодорхой хугацааны дараа өрдийн ашиглалтыг нь хангах засвар үйлчилгээнээс өөр өөрчлөлт өрөлгүй буцаан гаргах нөхцөлөөр импортлогдох ёстой);~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Гаалийн түр зөвшөөрөл / Temporary admission** гэж зарим барааг импортын татвар, хураамжаас тодорхой нөхцөлтэйгээр бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлж болох гаалийн журмыг; Ийм барааг тодорхой зорилгоор импортлох ба заасан хугацаанд хэрэглээнээс шалтгаалсан элэгдэл хорогдлоос бусад аливаа өөрчлөлтгүйгээр рэ-экспорт хийдэг байх ёстой.

1.3.7. "Импортын барааны татвар, хураамж" гэж барааг импортлох үед ногдуулах гаалийн татвар болон бусад татвар, хураамж, төлбөрийн нийлбэрийг /эрх бүхий төрийн байгууллагуудын өмнөөс гаалийн байгууллагын үзүүлж **буй байгаа** үйлчилгээний болон түүнтэй холбоотой бусад төлбөрүүд үүнд хамаарахгүй/;

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Импортын барааны татвар, хураамж / Import duties and taxes** гэж барааг импортлох, үүнтэй холбоотой ногдуулах гаалийн татвар болон бусад татвар, хураамж, төлбөрийн нийлбэрийг. Үндэсний бусад байгууллагын өмнөөс гаалийн байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээний нийт хураамж болон түүнтэй холбоотой бусад төлбөр, хураамжийн дүн үүнд хамаарахгүй. (AN 9)

1.3.8. "Машинаар уншигдах аяллын баримт бичиг" гэж ~~иргэний нисэхийн олон улсын байгууллагын Док 9303-ын стандартад нийцүүлсэн, зориулалтын тоног төхөөрөмжөөр уншуулахад баримт бичигт тусгагдсан мэдээлэл нь цахим хэлбэрт шилждэг баримт бичгийг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Цахим аяллын цахим баримт бичиг / eMRTD** гэж Doc 9303 "Машинаар уншдаг аяллын баримт бичиг"-т заасан стандартын дагуу аяллын баримт бичиг эзэмшигчийг нь биометрийн өгөгдлөөр таньж тогтоох чадвартай бөгөөд мэдээллийг нь зайнаас уншиж болохоор өөрт нь суулгасан цахим-аяллын баримт бичиг (паспорт, виз, эсхүл карт) (AN 9)

1.3.9. "Мансууруулах ~~эм, сэтгэцэд нөлөөт~~ бодисын хяналт" гэж ~~хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг агаарын хөлгөөр хууль бусаар тээвэрлэхэд тавих хяналт, шалгалтын арга хэмжээг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Мансууруулах бодисын хяналт / Narcotics control** гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг агаараар хууль бусаар тээвэрлэхэд тавих хяналтын арга хэмжээг (AN 9)

1.3.10. "Хилийн хяналтын байгууллага" гэж Монгол Улсын хилийн тухай хуулийн 3.1.16-д заасан байгууллагыг;

1.3.11. "Хилийн хяналтын хоёр (улаан, ногоон) гарцын тогтолцоо" гэж хилийн хяналтын байгууллага нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог ашиглан агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигч болон бараа, бүтээгдэхүүнийг шалгах аргачлалыг;

1.3.12. "Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч" гэж ~~Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д тодорхойлсон этгээдийг;~~  
ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

**Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч / Disabled passenger** гэж агаарын тээврийн үйл ажиллагааны үед бие махбодь, эрүүл мэнд, эсхүл сэтгэхүйн нөхцөлөөс шалтгаалан ердийн зорчигчоос илүү тусгайлсан анхаарал халамж шаарддаг зорчигчийг;

1.3.13. "Хүлээн зөвшөөрөгдөөгүй зорчигч" гэж Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсад орохыг үл зөвшөөрсөн гадаадын иргэнийг;

1.3.14. "Хэв журам зөрчсөн зорчигч" гэж ~~агаарын хөлгөөр зөрчих журам болон олон улсын нислэгийн журам зөрчсөн, нисэх буудал, хилийн хяналтын байгууллагын ажилтан, агаарын хөлгийн багийн зааврыг үл дагаж нисэх буудлын болон нислэгийн хэвийн ажиллагааг алдагдуулж буй этгээдийг;~~

ИНД-ийн нэр томъёоны тайлар / AC01-0 Annex definitions and abbreviations:

**Хэв журам зөрчсөн зорчигч / Unruly passenger** гэж агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулсан, эсхүл учруулахаар завдсан, эсхүл агаарын хөлөг дотор санаатайгаар нийтийн хэв журам зөрчсөн этгээдийг; (AN 9)

1.3.15. "Хэрэгцээгүй чирэгдэл саатал" гэж агаарын хөлөг, агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигч, ачаа шуудан, бусад эд зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцогч агаарын тээвэрлэгч, хилийн хяналтын болон бусад байгууллагын харилцан уялдаагүй, давхардсан, боловсронгуй бус үйл ажиллагаанаас шалтгаалж тэдгээрийн хөдөлгөөнийг саатуулах ажиллагааг;

1.3.16. "Эрсдэлийн удирдлага" гэж ~~эрсдэл бүхий бараа, хөдөлгөөний талаар хилийн хяналтын байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж менежментийн арга, туршлагыг мөрдөж хэрэгжүүлэх системчилсэн үйл ажиллагааг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Эрсдэлийн удирдлага / Risk management** гэж хилийн хяналтын байгууллагыг эрсдэлийг агуулсан хөдөлгөөн, эсхүл илгээх барааг тодорхойлоход шаардлагатай мэдээллээр хангадаг удирдлагын журам болон практик туршлагын системчилсэн хэрэглээг (AN 9)

1.3.17. "Аяллын цахим систем" гэж зорчигчоос Монгол Улсад зорчихоор гаргасан хүсэлтийг хүлээн авах, шалгах, цаасан визний оронд цахим виз олгох системийг;

1.3.18. "Залилагч" гэж бусдын ~~хууль ёсны~~ баримт бичгийг хууль бусаар ашиглан хил нэвтрэхийг оролдсон **этгээдийг хүнийг;**

1.3.19. "Зорчигчийн өгөгдлийн нэг цонх" гэж агаарын тээврийн үйлчилгээнд оролцогч байгууллагууд зорчигчийг хилээр нэвтрүүлэхэд төрийн байгууллагуудаас тавьдаг шаардлагад дурдсан стандартчилагдсан мэдээллийг нэг цэгт байршуулсан системийг;

1.3.20. ~~“Зорчигчийн урьдчилсан мэдээллийн интерактив систем” гэж агаарын тээвэрлэгчээс зорчигч бүртгэлийн явцад цуглуулсан мэдээллийг хилийн хяналтын байгууллагуудад илгээх, хилийн хяналтын байгууллага мэдээллийг хянаж, зорчигчийг бүртгэх явцад буцаан хүргүүлэх цахим системийг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

**Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем / Advance Passenger Information (API) System** гэж Шаардлагатай өгөгдлийн хэсгийг нисэх буудалд нэвтрэх үндсэн хэсэгт ашиглахад бэлэн байхаар нисэн гарах, эсхүл нисэн ирэх нислэгийн өмнө хилийн хяналтын байгууллагад цуглуулж, дамжуулдаг электрон холбооны системийг (AN 9)

1.3.21. “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж” гэж Дэлхийн гаалийн байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах багц стандарт”-ын дагуу гаалийн байгууллагаас олгосон итгэмжлэл бүхий бараа нийлүүлэх сүлжээнд оролцогч /үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч, тээвэр зууч, агуулах эзэмшигч, бараа илгээгч/-ийг;

1.3.22. “Нэг цонхны үйлчилгээ” гэж гадаад худалдаа болон тээвэрлэлтэд оролцогч талуудад барааг улсын хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай баримт бичиг олгох, тэдгээрийг мэдээллээр хангах үйлчилгээг нэг цэгт үзүүлэхийг;

1.3.23. “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж агаарын тээвэрлэгч, эсхүл түүнээс эрх олгосон байгууллагын бэлтгэгдсэн ажилтнууд зорчигч агаарын хөлөгт суухаас өмнө дамжин өнгөрөх, зорчих улсын хилээр нэвтрэх аяллын баримт бичиг, шаардлагатай тохиолдолд виз, оршин суух зөвшөөрөлтэй эсэхийг шалгах үйл ажиллагааг;

1.3.24. “Харгалзан хүргэгч” гэж Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг үл зөвшөөрөх болон албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг дагалдуулахаар томилсон албаны хүнийг;

1.3.25. “Харгалзан дэмжигч” гэж насанд хүрээгүй хүнийг харгалзан дэмжиж, хамт зорчиж буй насанд хүрсэн зорчигчийг (Энэ хүн нь тухайн насанд хүрээгүй хүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч биш байж болно);

1.3.26. “Харгалзан дэмжигчгүй зорчигч” нэг болон түүнээс дээш тооны хамт зорчиж буй насанд хүрээгүй хүнийг;

1.3.27. “Цахим автомат гарц” гэж Монгол Улсын иргэний гаргасан хүсэлтийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, үндэсний гадаад паспорт болон биеийн давхцахгүй өгөгдлийг шалгаж, улсын хилээр нэвтрүүлэх суурин автомат төхөөрөмжийг;

1.3.28 ~~“Нисэх багийн гишүүний гэрчилгээ~~ буудлын нэвтрэх үнэмлэх / Airport identity cards” болон “~~Нисэх~~ багийн гишүүний биеийн байцаалт” гэж ~~нисэх~~ багийн гишүүдийг улсын хилийн цахим гарцаар нэвтрэхэд шаардагдах аяллын баримт бичгийг. ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

**Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх / Airport identity card** гэж ИНД-140-ийн дагуу олгосон, эсхүл зөвшөөрсөн нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг;